



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/328

Улаанбаатар хот

Түр горим батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологийн түр горимыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү түр горимыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт), "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газар (А.Буяннэмэх) болон төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нарт тус тус даалгасугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат), Салбарын хяналтын газар (Б.Бат-Өлзий)-т тус тус даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны 12 сарын 15-ний өдрийн
А/328 дугаар тушаалын хавсралт



**ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНД СУУРЬ БҮТЭЦ ХООРОНД
ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
НЭГДСЭН ТЕХНОЛОГИЙН ТҮР ГОРИМ**

ЗӨВШӨӨРСӨН:

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-НИЙ
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ТӨХК-НИЙ

Т.БАТЗОРИГ

"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХНН-НИЙ
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН ОРЛОГЧ

ХНН-НИЙ

Н.МӨНХЦООЖ

"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-НИЙ
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ХХК-НИЙ

Г.АНХБАЯР

"МОНГОЛИАН ТРАНС ЛОЖИСТИК" ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХХК-НИЙ

М.СҮХБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨМӨР
ЗАМ ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА:

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ УЛСЫН
ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗУРМАГ
ШИНЖИЛГЭЭНИЙ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨМӨР
ЗАМ ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХНН-НИЙ
ТЕХНИКИЙН БОДЛОГО, СТАНДАРТЧИЛЛЫН
АЛБАНЫ ОРЛОГЧ ДАРГА

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-НИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-НИЙ
ТЭЭВРИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХНН-НИЙ
ТЭЭВЭР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ
ЗУРМАГ ЗОХИОГЧ ИНЖЕНЕР

"МОНГОЛИАН ТРАНС ЛАЙН" ХХК-НИЙ
ХӨДӨЛГӨӨНИЙ АЛБАНЫ ДАРГА

Х.ИТГЭЛТ

Ж.АЛИМАА

Б.БАТНАСАН

Л.ЭНХБОЛД


Г.ШИЖИРБААТАР

Б.БАТБАЯР


Б.БАТЗОРИГ

Ж.ЭНХСАЙХАН

АГУУЛГА	
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1. Зорилго	5
1.2. Хамрах хүрээ	5
1.3. Хэрэглэх нэр томъёо	5
1.4. Техникийн шаардлага	6
1.4.1. Суурь бүтэц	6
1.4.2. Суурь бүтцээр нэвтрэх вагонд тавигдах техникийн ерөнхий шаардлага	6
1.4.3. Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүрт тавигдах шаардлага	6
1.4.4. Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүрийн бригадад тавигдах шаардлага	7
1.4.5. Суурь бүтцээр нэвтрэх тусгай хөдлөх бүрэлдэхүүнд тавигдах шаардлага	7
1.4.6. Мэдээллийн цахим системд тавигдах шаардлага	7
ХОЁР. ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
2.1. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн удирдлага	7
2.2. Ашиглалтын ажлын техникийн норм	8
2.3. Төмөр замын сүлжээний хэмжээнд хоногийн ажлын төлөвлөлт	10
2.4. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг	11
2.5 Төмөр замын суурь бүтэц дэх тээвэрлэлтийн үйл ажиллагаа	12
2.6. Галт тэрэг найруулах төлөвлөгөө	14
2.7. Галт тэрэгний жин, урт	15
2.8. Галт тэрэг дугаарлалт	16
ГУРАВ. ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АШИГЛАЛТ, ЗАСВАРЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	16
3.1. Зүтгүүр парк, зүтгүүрийн бригадын ажлын удирдлага зохион байгуулалт	16
3.2. Зүтгүүрийн эргэх мөр, зүтгүүрийн бригадын ажиллах хэсэг, ачааны галт тэрэгний урт, жингийн норм тогтоох тухай	16
3.3. Зүтгүүрийн зэхэлт зохион байгуулалт	17
3.4. Зүтгүүрийн бригадын ажиллах нөхцөл	17
3.5. Вагоны засвар үйлчилгээ, ажлын зохион байгуулалт	17
ДӨРӨВ. АЧАА ТЭЭВРИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	18
ТАВ. ТӨМӨР ЗАМЫН ӨРТӨӨНИЙ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	20
5.1. Суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох, ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх	20
5.2. Дамжуулах өртөөнд галт тэрэг солилцох хугацаа	23
5.3. Суурь бүтцээр нэвтрэх ачаа тээвэрлэх галт тэрэгний технологит ажилбар	23
ЗУРГАА. СУУРЬ БҮТЦИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ, “ЦОНХ”-НЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ	27
ДОЛОО. ТЭЭВРИЙН ТӨЛБӨР ТООЦООГ ХИЙХ АЖИЛЛАГАА	27
НАЙМ. ТЭЭВРИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ АЖИЛЛАГАА	28
8.1. Тээврийн гэрээ байгуулах	28




ЕС. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЖИЛЛАГАА	28
9.1 Мэдээлэл солилцоо	28
АРАВ. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ	30
АРВАН НЭГ. ХАВСРАЛТ	32
Хавсралт № 11.1. Монгол Улсын төмөр замын сүлжээ	32
Хавсралт № 11.2. Суурь бүтцүүдийн техникийн тодорхойлолт	33
Хавсралт № 11.3. Суурь бүтэц эзэмшигчийн тээврийн хөдөлгөөн зохицуулах нэгжийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт	39
Хавсралт № 11.4. Төмөр замуудын уулзварын өртөө хооронд солилцох галт тэрэгний	43
Хавсралт № 11.5. Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүрийн эргэлтийн бүдүүвч	44
Хавсралт № 11.6. Галт тэрэгний техникийн байдлыг хангах мөр	45
Хавсралт № 11.7. Суурь бүтцээр нэвтрэх вагонуудын техникийн байдлыг хангах мөрний бүдүүвч	47
Хавсралт № 11.8. Ачааны захиалга хүлээн авах, зөвшилцөх бүдүүвч	48
Хавсралт № 11.9. Сайжруулсан шахмал түлшний түүхий эд мидлинг тээвэрлэх технологит ажилбар	49
Хавсралт № 11.10. Төмөртэй-Эрээн /төмрийн хүдэр/ чиглэлд тээвэрлэлт хийх технологит ажилбар	52
Хавсралт № 11.11. Суурь бүтцээр нэвтрэх ачаа тээвэрлэлтийн төлбөр тооцоо хийх дараалал	57
Хавсралт № 11.12. Орон нутгийн харилцааны тээврийн падаан	58
Хавсралт № 11.13. Мидлинг тээвэрлэлтийн хатуу хуваарьт зурмаг	62



Ашигласан материал

- Төмөр замын кодчилол. 2-р хэсэг: Төмөр замын үйл ажиллагааны объектуудын байршлын нэгдсэн тоон кодчилол. MNS 6631-2:2016.
- “Төмөр замуудын ачаа тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээний технологийн процесс”. РЖД. 2012 он.
- УБТЗ-ын тээвэр зохион байгуулалтын ажлын Нэгдсэн технологийн процесс. 2020 он.
- “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК хооронд галт тэрэг солилцох технологийн түр горим. 2022 он.
- “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөр зам” ХХК хооронд галт тэрэг солилцох технологийн түр горим. 2022 он.
- “Монголын төмөр зам” ТӨХК, “Монголиан транс ложистик” ХХК-уудын “Зүүнбаян-Цагаанцав чиглэлийн төмөр замын өртөө зөрлөг болон 113-р километрээс салаалсан замд галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах түр журам”. 2022 он.
- Тавантолгой өртөөний технологийн горим 2023 он.
- “Монголын төмөр зам” ТӨХК, “Монголиантранс Лайн” ХХК-уудын “Цогтцэций-Цагаанцав-Номгон чиглэлийн замд галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах технологийн түр журам”. 2023 он.
- УБТЗ ХНН-БТЕГ ХХК-ны Төмөр замын хамтын ажиллагааны гэрээ. 2020 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ХАГ/20/009.
- “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-уудын “Суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох, ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх гэрээ” 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр АГГ-2023/21, АГГ-2023/17.



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын төмөр замын сүлжээнд суурь бүтэц хоорондын болон суурь бүтэц дамнасан тээвэрлэлтийг бүх суурь бүтэц эзэмшигч байгууллага хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

Тус гэрээнд суурь бүтцүүд тус тусын төмөр замд тавигдах техникийн шаардлага, хоорондоо галт тэрэг солилцох технологийн горим, дамжин өнгөрөх галт тэрэгний технологийн горим, тээврийн тариф, хоорондын төлбөр тооцоо, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, машинч нарын ажиллах нөхцөл, тээврийн гэрээ байгуулах, гэрээнд өөрчлөлт оруулах, тээврийн акт тогтоох, тээвэрлэгч ачааг саатуулах, тээвэрлэгчийн хариуцлагын зааг, гомдол гаргах, тээврийн шуурхай мэдээлэл солилцох зэрэг асуудлыг тусгасан байна.

Энэхүү технологийн түр горимыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, үндэсний стандартыг мөрдлөг болгож ажиллана.

Ачаа илгээгч тээврийн гэрээг зөвхөн гэрээт тээвэрлэгчтэй байгуулж, тээвэрт оролцох төмөр замуудын тарифыг нэгтгэсэн дүнгээр төлбөр тооцоог хийнэ. Тээвэрт оролцсон дайвар (дараагийн) тээвэрлэгч гэрээт тээвэрлэгчээс падаанд заасан тарифын дагуу тогтсон хугацаанд хоорондын тооцоогоор төлбөрөө авна.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь суурь бүтцээр нэвтрэн аялах галт тэрэгний хуваарь, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10.1.16, 10.1.17-д заасан тээвэрлэлт болон суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцох хуваарийн хэрэгжилтэд хяналт тавьж, онцгой нөхцөл үүссэн үед галт тэрэг солилцоог захирамжлан зохион байгуулна.

1.1. Зорилго

Монгол Улсын төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийн ажлыг зохион байгуулахад тавигдах шаардлага, тээвэрлэлтийн ажлын үйл явцыг төлөвлөх, удирдах, зохицуулах, хяналт тавих технологийн үндсэн зарчмыг болон суурь бүтэц эзэмшигч хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад оршино.

1.2. Хамрах хүрээ

Монгол Улсын төмөр замын сүлжээнд холбогдсон бүх суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч.

1.3. Хэрэглэх нэр томьёо

Энэхүү технологийн түр горимд хэрэглэсэн нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно:

“Гэрээт тээвэрлэгч” - тээврийн гэрээг илгээгч талтай байгуулсан тээвэрлэгчийг;


“Дараагийн тээвэрлэгч” - тээврийн гэрээнд оролцогч буюу тээвэрлэлтийг үргэлжлүүлэхээр ачааг хүлээн авч байгаа тээвэрлэгчийг;

“Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүр” - суурь бүтэц дамнасан тодорхой хэсэглэлд ашиглахаар тээвэрлэгч, суурь бүтэц эзэмшигч нарын харилцан зөвшилцсөн галт тэрэгний болон сэлгээний зүтгүүрийг;

“Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүрийн бригад” - суурь бүтэц дамнасан тодорхой хэсэглэлд ажиллуулахаар тээвэрлэгч, суурь бүтэц эзэмшигч нарын харилцан зөвшилцсөн машинч, туслах машинчийг;

“Уулзварын цэг” - хоёр төмөр замын суурь бүтэц эзэмшигчийн эд хөрөнгийн өмчлөлийн дуусгавар болох цэг буюу хоёр талын зам төмөр болон бусад шугам сүлжээгээр холбогдож буй цэгийг;

“Суурь бүтцүүдийн уулзварын өртөө” - хоёр суурь бүтэц эзэмшигч хоорондын галт тэрэгний хөдөлгөөний хариуцлага өөрчлөгдөх газрыг;



“Төмөр замын тээврийн байгууллага хооронд ачаа, зорчигч, вагон, галт тэрэг дамжуулах өртөө” - гэж хоёр төмөр замын тээврийн байгууллага хооронд ачаа, зорчигч, вагон болон галт тэрэгний хариуцлага өөрчлөгдөх өртөөг; (Энэ нь тухайн газарт ирсэн галт тэргийг нэг төмөр замын тээврийн байгууллага нөгөө төмөр замын тээврийн байгууллага дамжуулах болохыг тодорхойлно)

“Суурь бүтцээр нэвтрэх ачаа” - гэж төмөр замуудын суурь бүтцээр дамжин өнгөрөх, суурь бүтэц хооронд тээвэрлэгдэх ачааг;

“Суурь бүтцээр нэвтрэх вагон” - гэж төмөр замуудын суурь бүтцээр дамжин өнгөрөх, суурь бүтэц хооронд тээвэрлэлтэд оролцох вагоныг.

1.4. Техникийн шаардлага

1.4.1. Суурь бүтэц

Суурь бүтцээр нэвтрэх тээвэр хийхэд төмөр замын суурь бүтцийн техник болон барилга ойртолтын овор, хурд, голын даац зэргүүдийн хамгийн бага үзүүлэлтийг баримтлан галт тэрэг солилцоно.

Суурь бүтцүүдийн техникийн үзүүлэлтийг хавсралт № 11.2 -оор хавсаргав.

1.4.2. Суурь бүтцээр нэвтрэх вагонд тавигдах техникийн ерөнхий шаардлага.

Суурь бүтцээр нэвтрэх вагоны техникийн байдал нь “Ашиглалтын үед вагонд техникийн үзлэг, үйлчилгээ хийх заавар”-ын шаардлагад нийцэж байвал зохино.

Суурь бүтцээр нэвтрэх вагоны талаарх мэдээллийг урьдчилан солилцож, зөвшилцсөн байна. Солилцох мэдээлэлд дараах өгөгдлүүд багтсан байна. Үүнд:

- Вагоны дугаар;
- Засварын хугацаа;
- Үйлдвэрлэсэн он;
- Вагоны загвар.

Вагон эзэмшигч нь вагонуудын засвар үйлчилгээтэй холбоотой сэлбэгийн бууршгүй нөөцийг суурь бүтэц эзэмшигчтэй зөвшилцөн байршуулна.

Суурь бүтцээр нэвтрэх вагон нь төлөвлөгөөт засварт орох хугацаа дуусахаас өмнө харьяалагдах суурь бүтэц рүү очсон байх хугацааг хангасан байна.

1.4.3. Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүрт тавигдах шаардлага


Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүр нь “Төмөр замын техник ашиглалтын журам”-ын шаардлагыг хангасан байна. Зүтгүүрийн нэг голоос дарах даралт нь тухайн суурь бүтцийн замын даацаас хэтрээгүй байна;

Суурь бүтцүүд нь дамжин тээвэрлэлт хийх зүтгүүрийн мэдээллийг урьдчилан солилцож, зөвшилцсөн байна;

Зүтгүүрийн радио холбоо нь аялал хийж байгаа тухайн суурь бүтцийн галт тэрэгний радио холбооны төхөөрөмжтэй саадгүй холбогддог байна;

Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүрийг талуудын үйлдсэн “Зүтгүүрийн техникийн магадлагаа” (ТУ-25)-г үндэслэн нэвтрүүлнэ; (Уг магадлагааны хуулбарыг зүтгүүрт байрлуулна)

Зүтгүүрийн засвар үйлчилгээ, техникийн байдалд тавих хяналтыг талуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна;



Энэхүү горимоор зохицуулагдаагүй зүтгүүр болон зүтгүүрийн бригадтай холбоотой зохион байгуулалт, үйл ажиллагаа, төлбөр тооцооны болон бусад асуудлыг талуудын хоорондын гэрээгээр зохицуулна.

1.4.4. Суурь бүтцээр нэвтрэн ажиллах зүтгүүрийн бригадад тавигдах шаардлага

Суурь бүтцээр нэвтрэх зүтгүүрийн бригад нь тухайн суурь бүтцийн мэргэжлийн комисст шалгалт өгч тэнцсэн байна;

Дээрх шалгалтад тэнцсэн зүтгүүрийн бригадтай тухайн суурь бүтцийн зааварлагч машинч зүгшрүүлэлтийн аялал хийж, зөвшөөрөл олгоно;

Зааварлагч машинч нь бусад суурь бүтцийн замд өөрийн зүтгүүрийн бригадад зүгшрүүлэлт хийх эрхтэй. Галт тэргийг бие даан жолоодох зөвшөөрлийг зөвхөн тухайн суурь бүтцийн зааварлагч машинч нар олгоно.

Зүтгүүрийн бригад нь тухайн суурь бүтцэд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, техник захирамжийн акт, заавартай танилцан түүнийг дагаж мөрдөж ажиллана.

Суурь бүтэц эзэмшигчийн бус зүтгүүрээр тээвэрлэлт хийх тохиолдолд тээвэрлэгч тал "Зүтгүүрийн техникийн магадлагаа"-ны акт (ТУ-25) бүрдүүлж, суурь бүтэц эзэмшигчид хүлээлгэн өгнө. Акт нь нэг сарын хугацаанд хүчинтэй байна.

1.4.5. Суурь бүтцээр нэвтрэх тусгай хөдлөх бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

Суурь бүтцээр нэвтрэх тусгай хөдлөх бүрэлдэхүүний талаарх мэдээллийг урьдчилан солилцож, зөвшилцсөн байна.

Тусгай хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг тухайн суурь бүтцэд мөрдөгдөж буй журмаар зохицуулна.

1.4.6. Мэдээллийн цахим системд тавигдах шаардлага

Суурь бүтэц нь цахим мэдээлэл солилцох дараах технологийн орчныг бүрдүүлсэн байна.

а) Шилэн кабел болон утасгүй сүлжээний орчин бүрдүүлж, холболтыг найдвартай зохион байгуулсан сүлжээний дэд бүтэц (програм болон сүлжээний техник хангамж, дамжуулах төхөөрөмж)-тэй байх;

б) Стандартын шаардлага хангасан дата серверийн төвтэй байх;

в) Мэдээллийн нэгдсэн удирдлагын систем хэрэгжүүлж нэвтрүүлсэн байх;


г) Суурь бүтцүүдэд ашиглаж байгаа мэдээллийн системүүд нь хоорондоо холбогдсон байна.

ХОЁР. ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн удирдлага

2.1.1. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв (цаашид "хөдөлгөөн зохицуулалтын төв" гэх) нь хөдөлгөөний нэгдсэн зурмагийг цаглабарын дагуу боловсруулах, өөрчлөлт оруулах, зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх болон хяналт хийх, түүнд тавигдах шаардлагыг хангана.

2.1.2 Хөдөлгөөн зохицуулалтын төв нь галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой захирамж гаргана. Үүнд:



а) “Хөдөлгөөн зохицуулалтын төв”-ийн захирал нь суурь бүтэц эзэмшигчийн удирдлагад албан даалгавраар,

б) “Хөдөлгөөн зохицуулалтын төв”-ийн тээврийн удирдлагын нэгжийн дарга нь суурь бүтцүүдийн хөдөлгөөн хариуцсан нэгжийн удирдлагад шуурхай мэдээллийг суурин болон үүрэн утсан харилцаагаар тус тус өгнө.

Суурин болон үүрэн утсан харилцаагаар өгсөн чиг үүргийг бичиж гарын үсгээр баталгаажуулсан байна.

2.1.3. “Хөдөлгөөн зохицуулалтын төв” нь суурь бүтцээр нэвтрэх удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангахаар “Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ыг хэрэгжүүлнэ.

2.1.4. “Хөдөлгөөн зохицуулалтын төв” нь суурь бүтцээр нэвтрэх галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь бүтэц эзэмшигчид мэргэжил, арга зүйн зөвлөмжийг албан бичгээр хүргүүлж ажиллана.

2.1.5. Суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан зохион байгуулах үүрэгтэй нэгж (цаашид диспетчерийн удирдлагын төв гэх) нь удирдлагаар ханган, дараах ажиллагаануудыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. Үүнд:

а) Галт тэрэгний хөдөлгөөний хоногийн болон ээлжийн ажлын үүрэг даалгаврыг биелүүлэхтэй холбоотой диспетчерийн нэгдсэн ээлжийг зохион байгуулах;

б) Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг хангах;

в) Хилийн өртөө болон суурь бүтцүүдийн уулзварын өртөөдөөр (цаашид “уулзварын өртөө” гэх) галт тэрэг нэвтрүүлэх ажиллагааг саадгүй гүйцэтгэх;

г) Галт тэрэгний ба хөдөлмөрийн аюулгүй байдал, өртөөдийн техник захирамжийн акт, технологи, суурь бүтэц эзэмшигчийн өртөөтэй нийлсэн салбар замын өртөө хоорондын үйл ажиллагааны нэгдсэн технологийн горим зэрэг нормативын баримт бичгийн шаардлагыг хангах;

д) Орон нутгийн ажлыг удирдах;

е) Суурь бүтцийн засвар үйлчилгээ, барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр цаг хугацаанд нь “Цонх” гаргах;

ё) Зүтгүүрийн бригадыг үр бүтээлтэй ашиглах;

ж) Зүтгүүрийн паркийн ашиглалт, арчлалтад хяналт тавих;

з) Ачилтын нөөцийг тохируулах;

и) Орон нутгийн ажлыг зохион байгуулах;

й) Ажлын паркийн вагоныг хянах;

к) Галт тэрэгний хөдөлгөөнд гарсан гэмтэл, саатлыг цаг хугацаанд нь арилгуулахаар суурь бүтцүүдийн удирдлагын шийдвэрээр сэргээн босгох, аж ахуйн галт тэргийг өнгөрүүлэх нөхцөлийг хангах зэрэг болно.

2.2. Ашиглалтын ажлын техникийн норм

Суурь бүтэц эзэмшигч нь техникийн нормыг боловсруулахдаа дараах өгөгдөлийг үндэслэнэ. Үүнд:

а) Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөө, ачилтын захиалга;


б) Зүтгүүр ба вагоны тоо, байршил;

в) Суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар;

г) Өртөө болон ачааны терминалын ачаа боловсруулах чадвар;

д) Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг;

е) Галт тэрэг найруулах төлөвлөгөө зэрэг болно.



Техникийн нормоор тээвэрлэлтийн ажлын тоон, чанарын үзүүлэлтийн болон хөдлөх бүрэлдэхүүнээр хангах нормыг тогтооно.

Суурь бүтэц эзэмшигч нь сар эхлэхээс 15 хоногийн өмнө дараа сарын тээвэрлэлтийн төлөвлөгөөг суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн техник технологийн боломжийг судалж гаргана. Үүнд:

а) Хоосон вагоны хэрэгцээг тохируулахын тулд түүний тэнцлийг вагоны төрлөөр тооцоолох;

б) Хоосон вагонуудыг төрөл болон эзэмшигчээр хуваарилан тэдгээрийн хоосон гүйлт хамгийн бага байх зарчмыг баримтлан, дөт чиглэлийг сонгон, замуудын уулзвар өртөөдөд хүргэх бүдүүвчийг боловсруулах;

в) Уулзварын өртөө бүрээр нэвтрэх хоосон вагон урсгалын нормыг тооцоолох;

г) Хилийн өртөө болон уулзварын өртөөдөөр солилцох ачаатай, хоосон вагоны нормыг тооцоолох;


д) Хилийн өртөө болон уулзварын өртөөдөөр солилцох галт тэрэгний тоог тооцоолох зэрэг болно.

Буулгалт - Салбар замд буусан болон ачаатайгаар бусад суурь бүтэц эзэмшигч, улсад хүлээлгэн өгсөн вагоноор тодорхойлогдоно.

Ажлын парк – Суурь бүтцийн хэмжээнд байгаа ажлын паркийн нийт вагоныг ачаатай, хоосон болон вагоны төрлөөр тодорхойлно.

Хүснэгт № 1. Суурь бүтэц эзэмшигчийн ачилтын төлөвлөгөө боловсруулах технологит ажилбар

Гүйцэтгэгч	Үзүүлэлтүүд	Хоног																	
		1	1	1	1	1	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	3
		5	6	7	8	9	0	1	2	3	4	5	6	7	8	9	0		
Хөдөлгөөн зохион байгуулалтын нэгж	Суурь бүтцийн нэвтрүүлэх чадварын хязгаарлалтыг тооцон төлөвлөгдөж байгаа сарын ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөг (ачааны хэмжээ) хангах вагон урсгалын диаграммыг урьдчилсан байдлаар зохиох-1 хоног																		
	Ачилтын төлөвлөгөөг вагоноор, вагоны төрлөөр зохиох-3 хоног																		
	Вагон урсгалын ташуу хүснэгтийг вагоны төрлөөр зохиох-1 хоног																		
	Ачаатай вагоны ташуу хүснэгтийг хэлэлцэж үнэлгээ өгөх, шаардлагатай бол өөрчлөлт оруулж эцсийн байдлаар зохиох																		
	Ачилтын төлөвлөгөөг вагоноор болон ачааны төрлөөр эцсийн байдлаар төлөвлөх																		
	Вагон эргэлтийн нормыг ачааны төрлөөр нь урьдчилан тодорхойлох (транзит, орон нутаг, хоосон вагон)																		
	Вагоны төрлөөр тохируулан тооцоолох																		
	Буулгах вагоны нормыг вагоны төрлөөр тодорхойлох																		
	Хоосон вагон урсгалын ташуу хүснэгтийг оруулах, гаргах өртөөдөөр вагоны төрлөөр зохиох																		
	Хилийн өртөө болон уулзварын өртөөдөөр хоосон вагон солилцооны норм, /вагоны төрлөөр/																		
	Хилийн өртөө болон уулзварын өртөөдөөр нэвтрэх галт тэрэгний хэмжээ /галт тэргээр/																		
	Ажлын паркийн ачааны вагоны тооцоо, эзэмшигчээр, бүтцээр (транзит, хоосон, орон нутаг) вагоны төрлөөр																		
	Ашиглалтын ажлын техникийн төлөвлөгөөний тайлбар бичиж замын удирдлагад танилцуулах																		
	Ачааны вагоны эргэх хугацааны тооцоо эцсийн байдлаар бүгд бүтцээр (транзит, хоосон, орон нутаг)																		
	Суурь бүтэц эзэмшигч сарын төлөвлөгөөг батлах																		
Нийт хугацаа /12 хоног/																			



2.3. Төмөр замын сүлжээний хэмжээнд хоногийн ажлын төлөвлөлт

2.3.1. Суурь бүтцийн галт тэрэгний хөдөлгөөний ахлах диспетчерүүд нь 12:00 цагаас өмнө дараа хоногийн төлөвлөгөөг урьдчилан тохиролцоно.

2.3.2. Суурь бүтцүүд нь дараа хоногт хилийн өртөөгөөр солилцох болон суурь бүтцээр нэвтрэх галт тэрэгний төлөвлөгөөг 17:00 цагаас өмнө галт тэрэгний хөдөлгөөний зохицуулалтын нэгдсэн төвд дамжуулна.

2.3.3. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв Монгол Улсын төмөр замын сүлжээний хэмжээнд тээвэрлэлтийн хоногийн ажлын гүйцэтгэлд хяналт тавина. Үүнд:

- а) Ачилт – жин, вагоны тоо (үндсэн ачааны төрлөөр);
- б) Буулгалт – жин, вагоны тоо (хөдлөх бүрэлдэхүүний төрлөөр);
- в) Хилийн өртөө болон уулзварын өртөөдөөр хүлээн авсан, хүлээлгэн өгсөн галт тэрэг, вагон тоо, жин (ачаатай, хоосон);
- г) Зүтгүүр болон вагоны ажлын парк (суурь бүтэц бүрээр);
- д) Тусгай өгөгдсөн үүрэг даалгавар.

2.3.4. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн сүлжээний хэмжээнд галт тэрэгний ажлыг шуурхай удирдлагын бүх түвшинд дараах асуудлуудыг хамааруулан төлөвлөнө. Үүнд:


- а) Галт тэрэг найруулга ба галт тэрэгний ажлыг шуурхай төлөвлөх,
 - б) Ачааны галт тэрэгний зүтгүүр, зүтгүүрийн бригад тохируулах,
 - в) Түүвэр, зөөврийн болон нэвтрэх галт тэрэгний ажлыг шуурхай төлөвлөх,
 - г) Ачааны хоёрлосон ажиллагааг тооцсон ачилтын нөөцийг ашиглах,
 - д) Галт тэрэгний бүрэлдэхүүнд техникийн үйлчилгээ хийх ба ачааны вагоныг ачилтанд бэлтгэх газрын үзэгч, засварчдын тоог шуурхай тохируулах,
- 2.3.5. Суурь бүтэц эзэмшигчийн тээврийн зохион байгуулалт хариуцсан бүтцийн нэгж нь галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг төлөвлөхдөө дараах зорилтуудыг авч үзнэ.

- а) Галт тэрэг урсгалыг тасралтгүй жигд, саадгүй өнгөрүүлэх;
- б) Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тохируулан уулзварын өртөөдөөр ачааны галт тэрэг солилцох;
- в) Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтүүдийг биелүүлэх;
- г) Суурь бүтцийн нэвтрүүлэх чадварыг үр бүтээлтэй ашиглах;
- д) Ачаатай ба хоосон вагоны хүргэх хугацааг баримтлах;
- е) Техникийн өртөөд дэх ажиллагаатай ба ажиллагаагүй дамжин өнгөрөх вагоны зогсолтын нормыг биелүүлэх;
- ё) Гэмтэлтэй вагоныг засварын замд тавих, засварт байх хугацааны нормыг баримтлах;
- ж) Суурь бүтцэд хийгдэх төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажилд гаргах “Цонх”-ыг хугацаанд нь олгох;
- з) Галт тэргэнд техникийн үйлчилгээ хийх, техник үйлчилгээний газрын вагон үзэгчид болон зүтгүүр, зүтгүүрийн бригадыг оновчтой байршуулан үр дүнтэй ажиллах;

2.3.6. Хоногийн ажлыг төлөвлөх үед ачааны вагоныг ашигтайгаар хуваарилах, мөн түүнчлэн замын доторх вагон урсгалын тохируулга нь төлөвлөж байгаа галт тэрэгний хэмжээ хэсгийн нэвтрүүлэх чадвараас хэтрэхгүй байх асуудлыг тооцоолно.

Галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн хэсэг, хэсгийн өртөөдийг вагон, бүрэлдэхүүнээр хангах ажлыг тэдгээрийн хүчин чадлаас хэтрүүлэхгүй байхаар зохицуулна.

Суурь бүтэц эзэмшигчдийн хөдөлгөөн зохион байгуулах нэгжүүдийн бүтэц зохион байгуулалтыг хавсралт № 11.3-аар харуулав.



2.4. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг

2.4.1. Зурмагт тавигдах шаардлага

2.4.1.1. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг нь төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч бүх тээвэрлэгч, суурь бүтэц эзэмшигчдийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулан зохицуулах норматив технологийн үндсэн баримт бичиг болно.

2.4.1.2. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг нь төмөр замын техник ашиглалтын журмын дагуу дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а) Зорчигч болон ачаа, ачаан тээш тээвэрлэлтийн хэрэгцээг хангах;
- б) Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- в) Өртөөдийн боловсруулах болон хэсгийн тээх, нэвтрүүлэх чадварыг үр өгөөжтэй ашиглах;
- г) Хөдлөх бүрэлдэхүүн болон ачих буулгах техник хэрэгслийг үр бүтээлтэй ашиглах;
- д) Зүтгүүрийн бригадын тасралтгүй ажиллах, амрах цагийг нарийн мөрдөх;
- е) Зам, сум, хиймэл төхөөрөмж, ДТХ -ийн болон холбооны, цахилгаан эрчим хүчний байгууламжид засвар үйлчилгээ хийх боломжийг хангах;
- ё) Салбар замын тээвэрлэлтийн ажлыг уялдуулах;

2.4.1.3. Ачааны галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг зорчигчийн галт тэрэгний зурмаг, галт тэрэг найруулах төлөвлөгөөний хамт жил бүр зохион нэгэн зэрэг мөрдөнө. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг Монгол Улсын хууль, Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан зурмаг зохицуулалтын журмын дагуу боловсруулна.

2.4.1.4. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг зохиохын өмнө нормативын баримт бичиг бүрдүүлэх явцад галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой аж ахуйн нэгжийн хамтын үйл ажиллагааны технологийн журам, дарааллыг тогтоосон байна.

2.4.2. Зурмаг зохиох үндсэн өгөгдөл ба үзүүлэлтүүд

2.4.2.1. Үндсэн өгөгдөл:

- а) Галт тэрэгний хоорондын замуудаар явах цэвэр хугацаа;
- б) Хүч авалт удаашралтанд зарцуулах хугацааны норм;
- в) Завсрын өртөөдөд техник, ачаа тээврийн үйлчилгээ хийхээр зогсох хугацааны норм;
- г) Зүтгүүрт техникийн үйлчилгээ хийхээр эргэлтийн ба үндсэн депод зогсох хугацааны норм;
- д) Галт тэрэг хүлээн авах, явуулах, зөрүүлэх, өнгөрүүлэх үеийн галт тэрэг хоорондын хамгийн бага интервал (өртөөний интервал) болон багц галт тэрэг хоорондын интервал.


2.4.3. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн үндсэн үзүүлэлт:

А. Тоон үзүүлэлт

- Ачилт, буулгалтын хэмжээ;
- Ачааны болон зорчигчийн галт тэрэгний хэмжээ;
- Ачааны галт тэрэгний гүйлт (галт тэрэг/км, галт тэрэг/цаг);
- Зүтгүүрийн гүйлт (зүтгүүр/км, зүтгүүр/цаг);
- Галт тэрэгний ажил (цэвэр.тонн/км, бохир.тонн/км);
- Уулзварын өртөөдөөр солилцох галт тэрэг, вагоны тоо.

Б. Чанарын үзүүлэлт

- Техникийн, хэсгийн болон замналын хурд;
- Хурдны коэффициент;




- Зүтгүүрийн хоногийн дундаж гүйлт;
- Галт тэрэгний дундаж цэвэр, бохир жин;
- Ялгалтын, хэсгийн өртөөдөд ачааны галт тэрэгний дамжин өнгөрөх) дундаж зогсолт;
- Эргэлтийн өртөөнд зүтгүүрийн зогсох дундаж хугацаа;
- Зүтгүүрийн ашиглалтын болон эргэлтийн хугацаа.


2.5 Төмөр замын суурь бүтэц дэх тээвэрлэлтийн үйл ажиллагаа

Төмөр замаар ачаа тээвэрлэх үйл явцыг удирдан зохион байгуулахдаа суурь бүтэц тус бүрийн хөдөлгөөн зохицуулах бүтцийн нэгж нь тээвэрлэлтийн үйл ажиллагааг харуулсан дараах бүдүүвчид зааснаар тээвэрлэлтийн үйл явцыг нэгдсэн байдлаар зохицуулан хяналт тавина.

Зураг № 1. Төмөр замын суурь бүтэц дэх тээвэрлэлтийн үйл ажиллагааны бүдүүвч



Зураг № 2. Хэд хэдэн суурь бүтэц дэх тээвэрлэлтийн үйл ажиллагааны бүдүүвч



МОНГОЛЫН
ТАМ ТЭМРИЙН ХӨГ ЖЭЛНИЙ ДАМ
ЭХ ХҮВЬ
Саяд Тогийн нэрлэсэн ончигийн
2023.07.15/2023.07.15

2.6. Галт тэрэг найруулах төлөвлөгөө

2.6.1. Ачааны галт тэрэг найруулах төлөвлөгөөгөөр вагон урсгалыг оновчтой зохион байгуулах, ачаатай, хоосон вагонд сэлгээний ажлыг өртөөдийн технологи хугацааг баримтлан хийх, төмөр замын ашиглалтын тоон болон чанарын үзүүлэлтийг сайжруулах, үргүй зардлыг бууруулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулна.

2.6.2. Хэсгийн болон ачааны өртөөдөд найруулсан галт тэрэгнүүд нь дараах төрлүүдэд хуваагдана:


- а) Шууд - Хэд хэдэн хэсгээр ажиллагаагүй өнгөрөх галт тэрэг;
- б) Хэсгийн - Нэг техникийн өртөөнөөс дараагийн техникийн өртөө хүртэл ажиллагаагүй явах галт тэрэг;
- в) Түүвэр - Нэг хэсгийн хэд хэдэн завсрын өртөөнд зогсож ажиллагаа хийх галт тэрэг болон нэг ба хэд хэдэн хэсэгт байрлах өртөөдөд хаягтай вагонуудаар найруулна. Завсрын өртөөдөд хаяглагдсан вагонуудыг галт тэргэнд байрлуулах болон өртөөдөд ажиллах дараалал нь энэхүү журмын 2 дугаар хавсралтад тусгагдсан болно. (Түүвэр галт тэргийг тогтоосон жин, уртаас дутуу бүрэлдэхүүнтэйгээр аялуулж болно. Түүвэр галт тэргийг хэсгийн өртөөд дээр найруулах бөгөөд завсрын өртөөдөд галт тэргэнд вагон холбох, салгах ажлыг зохион байгуулна)
- г) Зөөврийн - Хэсгийн болон завсрын өртөөнөөс тулгуур өртөө болон түүний үйлчилдэг өртөөнд очих вагоноор найруулсан галт тэрэг. Мөн түүнчлэн ялгалтын өртөөнөөс ачааны өртөөнд хүргэх ачаатай, хоосон вагоноор найруулсан галт тэрэг. (Ялгалтын өртөөнөөс ачааны өртөөнд зөөвөрлөх галт тэрэгнүүдийг тогтоосон жин болон уртаас дутуу найруулан явуулж болно)
- д) Дамжуулах - Нэг замаас нөгөө зам, эсвэл нэг улсаас нөгөө улсад очих ачаатай ба хоосон вагоноор бүрдсэн, мөн суурь бүтэц хоорондын уулзварын өртөөдөөр нэвтрэх галт тэрэг.
- е) Диспетчерийн мэдлийн зүтгүүр - Зөвхөн галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн шийдвэрээр тухайн хэсгийн болон завсрын өртөөдөд вагон хүргэх, ачилт буулгалтын фронтод тавих, татаж авч хэсгийн ба ялгалтын өртөөдөд хүргэх зүтгүүр. (Энэ галт тэргэнд бага хүчин чадал бүхий зүтгүүрүүд, бүх сэлгээний илчит тэрэгнүүдийг ашиглах ба шаардлагатай тохиолдолд зүтгүүрийн нэг секцийг ашиглаж болно)

2.6.3. Галт тэргэнд найруулсан вагонуудыг ачаатай, хоосон байдлаар:

- а) Ачаатай вагон бүхий галт тэрэг (Ачаатай вагонуудаас бүрдсэн галт тэрэг);
- б) Хоосон вагон бүхий галт тэрэг (Хоосон вагонуудаас бүрдсэн галт тэрэг);
- в) Холимог вагон бүхий галт тэрэг (Ачаатай болон хоосон вагонуудаас бүрдсэн галт тэрэг). Ийм төрлийн галт тэрэг найруулахдаа хүнд жинтэй болон урт бүрэлдэхүүнтэй бол хоосон вагоныг галт тэрэгний сүүлийн 3/1 хэсэгт, жингийн нормоос болон тухайн хэсэгт аялах уртаас хэтрээгүй бол ачааны галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу найруулна.

2.6.4. Галт тэргийг хүрэх төмөр замаар нь бүлэглэн найруулна. Ачаатай хоосон бүхий галт тэргийг найруулахдаа хүнд жинтэй болон урт бүрэлдэхүүнтэй бол хоосон вагоныг галт тэрэгний сүүлийн 1/3 хэсэгт найруулна.

2.6.5. Суурь бүтэц эзэмшигч бүр өөрийн суурь бүтцийн нэвтрүүлэх чадвар, галт тэрэгний хөдөлгөөний онцлог, техникийн өртөөний байршил (ялгах, хэсгийн, хилийн), түүний ажлын технологит ажилбар, зүтгүүр, вагоны парк, ашиглалтын (үзлэгийн мөр) байдал зэрэг онцлогт нийцүүлэн "Галт тэрэг найруулах төлөвлөгөө"-г боловсруулж мөрдүүлнэ.



Хүснэгт № 2 . Галт тэрэг найруулах төлөвлөгөө

Тэгш чиглэлд /зүтгүүр талаасаа/			
№	Найруулах суурь бүтэц, өртөө	Хүрэх галт тэрэг солилцох өртөө	Найрлага (Зам, суурь бүтэц)
1	МТЗ ТӨХК Төмөртэй	Хандгайт	МТЛо - ОХУ – УБТЗ – МТЛа - МТЗ – ТТЗ – БНХАУ
2	МТЛ ХХК Цагаанхаалга	Цагаанхаалга	БНХАУ – ТТЗ - МТЗ - МТЛайн – УБТЗ – ОХУ
3	МТЛ ХХК Номгон	Тавантолгой - Цогтцэций	ТТЗ – МТЗ
4	УБТЗ Сайншанд	Цогтцэций - Тавантолгой	ТТЗ - БНХАУ – МТЗ
5	УБТЗ Сайншанд	Номгон - Цогтцэций - Тавантолгой	МТЛа - МТЗ – ТТЗ - БНХАУ
6	УБТЗ Сайншанд	Номгон	БНХАУ - МТЛа
Сондгой чиглэлд /зүтгүүр талаасаа/			
№	Найруулах суурь бүтэц, өртөө	Хүрэх галт тэрэг солилцох өртөө	Найрлага (Зам, суурь бүтэц)
1	ТТЗ ХХК Тавантолгой	Цогтцэций - Сайншанд	ОХУ – МТЛо /МТЗ/ - УБТЗ – БНХАУ – МТЗ
2	ТТЗ ХХК Тавантолгой	Цогтцэций - Номгон – Сайншанд	МТЛа – БНХАУ - УБТЗ – МТЛо /МТЗ/ - ОХУ - МТЗ
3	ТТЗ ХХК Тавантолгой	Номгон	БНХАУ - МТЛ - МТЗ
4	МТЗ ТӨХК Цогтцэций	Номгон	БНХАУ – МТЛ
5	МТЛ ХХК Номгон	Сайншанд	ОХУ – МТЛо /МТЗ/ - УБТЗ - БНХАУ

Хүрэх өртөөгөөр нь галт тэргийг найруулахыг хоёр суурь бүтэц хоорондоо тохиролцож болно.


2.6.6. Галт тэрэг найруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн удирдлагын төв хяналт тавьж ажиллана.

2.7. Галт тэрэгний жин, урт

2.7.1. Галт тэрэгний жин болон уртын хэмжээг тухайн бүс нутгийн онцлог, бүс нутаг дахь суурь бүтэц эзэмшигч, ашиглагчдын дотоод журмаар тогтоох боловч өөр суурь бүтцээр нэвтрэх галт тэргийг найруулахдаа суурь бүтэц эзэмшигч, ашиглагч болон бусад сүлжээтэй хийсэн галт тэрэг солилцоо, хамтын ажиллагааны гэрээнд тусгасан байна.

2.7.2. Галт тэрэгний жингийн хугарал хийгддэг өртөөдөд галт тэргэнд вагон холбохдоо галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу бүс, чиглэл, ачааны нэр төрлөөр бүлэглэн найруулна.

2.7.3. Хоногийн ажлын төлөвлөгөө боловсруулахдаа хүнд жинтэй болон урт бүрэлдэхүүнтэй галт тэрэг тусгах бол галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмын дагуу тэмдэглэгээ хийнэ.



2.7.4. Шууд нэвтрэх галт тэрэгнээс техникийн болон ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан шалтгаанаар салгагдсан вагоныг тээвэрлэхэд бэлэн болсон, галт тэрэгний урт, жингийн хугарлаар салсан вагонуудыг галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу холбож явуулна.

2.7.5. Ачааны галт тэрэгний жингийн нормыг дор дурдсанаар тогтооно.

а) Ачааны галт тэрэгний жингийн нормыг суурь бүтэц эзэмшигч нар хамтарч тогтооно;

б) Дээрх ачааны галт тэрэгний жингийн хүлцэл ± 50 тонноос ихгүй байна;

в) Галт тэрэгний урт нь гэрээнд заасан томьёолсон вагоноос ихгүй байна.

Төмөр замуудын уулзварын өртөө хооронд солилцох галт тэрэгний урт болон жингийн хэмжээг хавсралт № 11.4 -өөр хавсаргав.

2.8. Галт тэрэг дугаарлалт

2.8.1. Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээнд нэгдсэн суурь бүтэц эзэмшигчийн аялж буй галт тэрэг бүр ангиллаасаа хамаарч дугаарлагдана.

2.8.2. Галт тэрэгний дугаарлалт хийх зааврыг Хөдөлгөөн зохицуулалтын төв боловсруулан баталж, суурь бүтэц эзэмшигчдэд хүргүүлнэ. Суурь бүтэц эзэмшигчид нь хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АШИГЛАЛТ, ЗАСВАРЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Зүтгүүр парк, зүтгүүрийн бригадын ажлын удирдлага зохион байгуулалт

Төмөр замын суурь бүтэц бүр зүтгүүрийн парк, зүтгүүрийн бригадын ажлын технологийн горимтой байна. Зүтгүүрийн бригадын ажлыг удирдах технологи нь дараах зүйлд үндэслэгдсэн байна. Үүнд:

а) Тухайн суурь бүтцийн хэмжээнд тогтоосон зүтгүүрийн эргэх мөр (зүтгүүрийн бригадын ажиллах хэсэг)-ийн урт, түүний бүдүүвч

б) Ачааны галт тэргийг зүтгүүр, зүтгүүрийн бригадаар үйлчлэх технологи, хэсэг тус бүрийн ажлын зохион байгуулалтын онцлог

в) Зүтгүүрийн бригадын ажил амралтын дэглэм, технологит ажилбаруудыг гүйцэтгэх үеийн хугацаа

Зүтгүүрийн кассетны бичлэг, ВУ-45, галт тэрэгний биечилсэн хуудас, анхаарамж холбогдох баримт бичгийг аялал бүрийн дараа суурь бүтэц эзэмшигчийн тууз орчуулагчид файлаар өгч болно.

Зүтгүүрийн гадна, доторх камер, радио станцын албан ярианы бичлэгийг шаардлагатай тохиолдолд суурь бүтэц эзэмшигчийн холбогдох газар, албанд өгнө.

3.2. Зүтгүүрийн эргэх мөр, зүтгүүрийн бригадын ажиллах хэсэг, ачааны галт тэрэгний урт, жингийн норм тогтоох тухай

Суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт, зүтгүүрийн аж ахуйг хариуцсан бүтцийн нэгж нь зүтгүүрийн эзэмшигчтэй хамтран суурь бүтцийн хэмжээнд мөрдөх зүтгүүрийн эргэх мөр, зүтгүүрийн бригадын ажиллах хэсгийн урт, бүдүүвчийг тогтооно.

Тухайн төмөр зам дээр аялах зүтгүүрийн татах жин, галт тэрэгний уртын нормыг зүтгүүрийн болон замын техникийн параметр, татах тооцоонд үндэслэн суурь бүтэц



эзэмшигч болон зүтгүүр эзэмшигч нар зөвшилцөн шийдвэрлэнэ.

Тээвэрлэгч нь тээвэрт ашиглах зүтгүүрийн мэдээллийг (сери, дугаар) суурь бүтэц эзэмшигчид өгнө. Зүтгүүрийн паркад өөрчлөлт орсон тохиолдолд албан бичгээр мэдэгдэнэ.

Зүтгүүрийн кассетын бичлэг, ВУ-45, галт тэрэгний биечилсэн хуудас, анхаарамж холбогдох баримт бичиг, зүтгүүрийн гадна, доторх камер, радио станцын албан ярианы бичлэгийг шаардлагатай тохиолдолд суурь бүтэц эзэмшигчийн холбогдох газар, албанд өгнө.

Суурь бүтэц хоорондын зүтгүүрийн эргэлтийн бүдүүвчийг хавсралт № 11.5-аар харуулав.

3.3. Зүтгүүрийн зэхэлт зохион байгуулалт

Депотой өртөөдөд гэрээний дагуу хөдлөх бүрэлдэхүүнд зэхэлтийг хийж гүйцэтгэнэ. Гэрээ хийгдээгүй нөхцөлд хөдлөх бүрэлдэхүүний зэхэлт хийх ажлыг хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч өөрөө хариуцан зохион байгуулна.

Түлш, элс, хөргөлтийн шингэн, тос, тослох материалын техникийн шаардлага хангалтыг гэрээгээр зохицуулна.

3.4. Зүтгүүрийн бригадын ажиллах нөхцөл

Суурь бүтэц хооронд дамжин ажиллах зүтгүүрийн бригадыг амрах байр, хоолоор хангах асуудлыг гэрээнд үндэслэн шийдвэрлэнэ.

Суурь бүтэц хооронд дамжин ажиллах зүтгүүрийн бригадын аяллын эхлэл, төгсгөлд тухайн суурь бүтэц эзэмшигчийн эмчийн үзлэгт хамруулсан байна.

Суурь бүтэц эзэмшигч нарын галт тэрэгний диспетчерүүд нь зүтгүүрийн бригадын ажил, амралтын дэглэмд хяналт тавина.

3.5. Вагоны засвар үйлчилгээ, ажлын зохион байгуулалт


3.5.1. Суурь бүтэц эзэмшигч, вагон эзэмшигч нар нь хоорондоо вагонд засвар үйлчилгээ хийх гэрээ байгуулсан байна. Гэрээнд вагоны засвар үйлчилгээний төрөл, засварын газрын байршил, сэлбэг эд ангиудын хангалт, төлбөр тооцоо, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтын тухай тусгасан байна.

3.5.2. Суурь бүтцээр нэвтрэх вагонуудын техникийн байдлыг хангах мөр, хариуцагчийг дараах байдалтай тогтооно. Үүнд:

- а) Сайншанд-Тавантолгой чиглэлд "Монголын төмөр зам" ТӨХК,
- б) Тавантолгой-Сайншанд чиглэлд "Тавантолгой төмөр зам" ХХК,
- в) Цогтцэций-Сайншанд чиглэлд "Монголын төмөр зам" ТӨХК,
- г) Тавантолгой-Номгон чиглэлд "Тавантолгой төмөр зам" ХХК,
- д) Цогтцэций-Номгон чиглэлд "Монголын төмөр зам" ТӨХК,
- е) Номгон-Таван толгой чиглэлд "Монголиантранс Лайн" ХХК,
- ё) Сайншанд-Номгон чиглэлд "Монголын төмөр зам" ТӨХК,
- ж) Номгон-Сайншанд чиглэлд "Монголиантранс Лайн" ХХК.

3.5.3. Суурь бүтцээр нэвтрэх вагонуудын техникийн байдлыг хангах мөрөнд бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй шууд аялна.

Галт тэрэгний техникийн байдлыг хангах мөрийг хавсралт № 11.6-аар харуулав.



3.5.4. Вагоныг төмөр замын тээврийн байгууллага хооронд ачаа, зорчигч, вагон, галт тэрэг дамжуулах өртөөнд (цаашид “дамжуулах өртөө” гэх) хүлээлцсэнээс хойшхи техникийн байдал, засвар үйлчилгээг хүлээн авсан суурь бүтэц эзэмшигч хариуцна.

3.5.5. Суурь бүтэц эзэмшигч нь вагоны техникийн үзлэг үйлчилгээнд хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд хяналт тавих төхөөрөмж, бусад техник технологи, аргачлалыг ашиглана.

3.5.6. Вагоныг дамжуулах өртөөнд вагон хүлээлцэх үед суурь бүтэц эзэмшигч нар вагон хүлээлцэх актыг үйлдэж, хоёр тал гарын үсгээр баталгаажуулна.

3.5.7. Вагоныг дамжуулах өртөөнд вагон хүлээлцэх үед илэрсэн гэмтлийг хүлээлгэн өгөх талын вагон-үзэгч засварчид засварлана. Вагонуудыг хүлээлгэн өгөх тал нь вагоны гэмтлийг засварлаагүй, эсвэл гэмтэлтэй, зориулалтын бус эд ангиар засварласан тохиолдолд хүлээн авах тал нь вагонуудыг хүлээн авахгүй.

3.5.8. Вагоныг дамжуулах өртөөнд хүлээн авсан вагонуудын актыг дараагийн суурь бүтэц эзэмшигч хүсэлтээр дамжуулан өгч болно.

3.5.9. Суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэлт, ачилт, буулгалтын үед вагоныг гэмтээсэн тохиолдолд вагон эзэмшигч болон хүлээлгэн өгсөн талд мэдэгдэх, акт баримт үйлдэх, шаардлагатай арга хэмжээ авна.

Суурь бүтцээр нэвтрэх вагонуудын техникийн байдлыг хангах мөрний бүдүүвчийг хавсралт № 11.7-оор харуулав.

ДӨРӨВ. АЧАА ТЭЭВРИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөө

4.1.1. Ачаа тээвэрлэлтийн сарын төлөвлөгөөг суурь бүтцийн техник, технологийн боломж, ачааны хэмжээ, нэр төрөл, захиалгын дагуу боловсруулна.

4.1.2. Ачаа тээвэрлэлтийг дараах байдлаар төлөвлөнө. Үүнд:

а) Тээвэрлэлтийг зохион байгуулахдаа үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж хамтран ажиллах;

б) Үйлчлүүлэгчээс ирүүлсэн тээвэрлэх ачааны хэмжээ, нэр төрөл, захиалгыг үндэслэн бусад суурь бүтцүүдтэй зөвшилцөх;


в) Тээврийн төлөвлөгөөг суурь бүтцүүдийн техник, технологийн боломжийг бүрэн ашиглан биелүүлэх;

Ачааны захиалга хүлээн авах, зөвшилцөх бүдүүвчийг хавсралт № 11.8-аар хавсаргав.

4.1.3. Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөний үндсэн зорилт нь суурь бүтцийн техник, технологийн боломжид тулгуурлан “Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөн”-өөр тохиролцсон хэмжээнд тээвэрлэх явдал юм.

4.1.4. Үйлчлүүлэгч төмөр замаар тээвэрлүүлэх ачааны захиалгыг орон нутгийн харилцаанд ачаа илгээх өртөөнд, олон улсын харилцаанд тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад ирүүлнэ. Ачаа тээвэрлүүлэх захиалгад хүрэх өртөөний нэр, код, салбар замын нэр, ачааны нэр түүний уялдуулсан нэрийн код, илгээлтийн төрөл зэргийг тусгасан байна. Олон улсын харилцаанд тээвэрлэх ачааны захиалгад хилийн дамжин өнгөрөх өртөөний нэрийг заана.

4.2. Орон нутгийн харилцаанд тээвэрлэлтийг зохион байгуулах ажиллагаанд дараах зүйлийг хамааруулна. Үүнд:



а) Үйлчлүүлэгчийн ирүүлсэн захиалга, тээвэрлэлтийн төлөвлөгөө, техникийн байдал, нормын дагуу ачилт, буулгалтын ажлыг зохион байгуулах;

б) Хоосон вагоныг захиалгын дагуу ачилтын өртөөдөд хүргэх;

в) Ачаатай вагоныг галт тэргэнд найруулж явуулах;

г) Орон нутгийн ачаатай, хоосон вагоныг салбар замд тавьж өгөх татаж авах;

д) Ачаа хүргэх хугацааг баримтлах;

е) Салбар зам эзэмшигчтэй суурь бүтцийг ашиглахаар байгуулсан гэрээг мөрдөх.

4.3. Төмөр замын суурь бүтэц эзэмшигч нь "Ачаа тээвэрлэлтийг төлөвлөх зохион байгуулах заавар, технологийн горим"-ыг боловсруулж мөрдөнө.

4.4. Суурь бүтэц эзэмшигчийн ачааны ажиллагаанд нээлттэй өртөөдөд ачааг хүлээн авч тээвэрлэнэ.

4.5. Суурь бүтэц эзэмшигч нь ачааны ажиллагаанд нээлттэй өртөөдөд өөрчлөлт оруулах тохиолдолд бусад суурь бүтэц эзэмшигчид жагсаалтыг хүргүүлнэ.

4.6. Төмөр замын сүлжээний хэмжээнд тээвэрлэлтийг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

а) Суурь бүтэц хоорондын тээвэрлэлт;

б) Суурь бүтцээр нэвтрэх тээвэрлэлт.

4.7. Уулзварын өртөөдөд ачаа хүлээлцэх технологийг "Суурь бүтэц хооронд ачаа солилцох гэрээ"-д заавал тусгана.

4.8. Олон Улсын харилцаанд ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах

4.8.1. Олон улсын харилцаанд тээвэрлэх ачааны хэмжээг дамжин өнгөрөх хилийн өртөө бүрээр галт тэрэгний тоо, хэмжээ (үүнээс хатуу зурмагийн болон чингэлгийн галт тэрэг) ачааны галт тэрэгний жин, урт зэргийг хилийн төмөр замуудын зөвлөгөөнтэй уялдуулж зохион байгуулна.


4.8.2. Олон улсын харилцаанд тээвэрлэлтийг зохион байгуулахдаа Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр, түүний хавсралтууд, "Албан заавар"-ыг мөрдлөг болгон ажиллана.

4.8.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын мэдээллийн системд төмөр замын хамтын нөхөрлөлийн гишүүн улсуудын төмөр замуудын сүлжээний өртөө, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, ачааны нэр, хөдлөх бүрэлдэхүүний талаарх өгөгдлийг коджуулсан байна.

4.8.4. Хамтын нөхөрлөлийн гишүүн улсуудын хоорондын вагон ба чингэлэг урсгалыг зохион байгуулах ажиллагааны мэдээлэл, технологийн чанарыг хангах, вагон урсгалын системийг хялбаршуулахын тулд төмөр замуудын захиргааны веб порталд чингэлэг ба вагоноор олон улсын галт тэрэг найруулах төлөвлөгөөний өгөгдлийн бааз байгуулна.

4.8.5. Төмөр замуудын суурь бүтцийн хэмжээнд ачааны захиалга авах, баталгаажуулах, тээврийн бичиг баримт үйлдэх ажиллагааг "Төмөр замаар ачаа тээвэрлэх журам"-аар зохицуулна.

4.8.6. Төмөр замын хилийн өртөөдөд галт тэрэг, вагон, ачаа хүлээлцэх, харилцан электрон мэдээлэл солилцох, вагон ашиглалтын төлбөр тооцоог хянах, автоматжуулсан систем ашиглах асуудлыг Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, ОХУ - Монгол Улс, БНХАУ - Монгол улс, ОХУ - Монгол Улс - БНХАУ-ын хилийн төмөр замын хамтарсан комиссын зөвлөгөөний протоколд зааснаар зохицуулна.



ТАВ. ТӨМӨР ЗАМЫН ӨРТӨӨНИЙ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох, ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх

5.1.1. Суурь бүтцийн төмөр замын уулзварын цэгт ойролцоо орших өртөөг сонгон галт тэрэгний хөдөлгөөний удирдлага шилжүүлэх уулзварын өртөөг тогтоож, “Суурь бүтэц хооронд ачаа солилцох гэрээ”-д заана.


5.1.2. Суурь бүтцийн төмөр замын уулзварын цэг гэдэг нь түүнд хамгийн ойрхон орших өртөөг хэлэх ба уг өртөөн дээр хоёр суурь бүтцийн хооронд галт тэрэг, ачааны хариуцлага шилжүүлэх дамжуулах өртөөг тогтоож, “Суурь бүтэц хооронд ачаа солилцох гэрээ”-д заах ба тээвэрлэгч, суурь бүтэц эзэмшигч нар хоорондоо тохиролцож аль нэг суурь бүтцийн уулзварын өртөөг сонгож болно.


5.1.3. Суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох, ачаа хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх ажиллагаанд дараах үлгэрчилсэн технологит ажилбарыг ашиглан, “Суурь бүтэц хооронд ачаа солилцох гэрээ”-д тусган, мөрдөж ажиллана.

5.1.4. Дамжуулах өртөөд галт тэргэнд хийгдэх үлгэрчилсэн технологит ажилбар болон ачаа тээврийн үзлэг хийх үлгэрчилсэн технологит ажилбарууд

Хүснэгт № 3. Дамжуулах өртөөд ирсэн тэгш, сондгой чиглэлийн галт тэргэнд хийгдэх үлгэрчилсэн технологит ажилбар

№	Гүйцэтгэх ажиллагаа	Хугацаа /хүртэл мин/	Хугацаа /мин/										Гүйцэтгэх ажилтан
			10	20	30	40	50	60	70	80	90	100	
1	Галт тэргийг өртөөнд ирэх цаг, хүлээн авах бэлэн байдлыг хангах талаар холбогдох ажилтнуудад мэдэгдэх.	Галт тэрэг ирэхээс өмнө											Өртөөний жижүүр
2	Галт тэргийг утгахаар хүлээн авах, явуулах зам руу очиж байрлал эзлэх.												Өртөөний жижүүр, туслах жижүүр хүлээлгэн өгөх, хүлээн авах талуудын вагон үзэгч, засварчин, ачаа вагон хүлээлцэгч
3	Галт тэргийг угтан авах үед вагоны техникийн болон ачааны бүрэн бүтэн байдалд хяналт тавих.	5 мин											Хүлээлгэн өгөх, хүлээн авах талуудын вагон үзэгч, засварчин, ачаа вагон хүлээлцэгч
4	Бүрэлдэхүүнийг тооцоот ивүүрээр бэхлэх, тээврийн баримт хүлээн авах, зүтгүүрийг гаргах.	10 мин											Туслах жижүүр, найруулагчийн бригад
5	Бүрэлдэхүүнийг хамгаалалтад авч, дэвтэрт тэмдэглэл хийх.	1 мин											Өртөөний жижүүр Хүлээн авах талын ахлах үзэгч, ачаа вагон хүлээлцэгч
6	Галт тэрэгний бүрэлдэхүүнийг биечилсэн хуудастай тулах.	10 мин 15 мин 20 мин 20 мин											Туслах жижүүр
7	Бүрэлдэхүүнд хүлээн авах тал техникийн болон ачаа тээврийн бүрэн үзлэг хийх. Хүлээлгэн өгөх талын вагон үзэгч техникийн үзлэгийн араас нь явж засварыг гүйцэтгэнэ.	15 мин 40 мин 65 мин 105 мин											Хүлээн авах талын вагон үзэгч-засварчин, ачаа вагон хүлээлцэгч, хүлээлгэн өгөх талын вагон үзэгч-засварчин





Жич: Галт тэрэгний техникийн бүрэн үзлэгийг 1 группийн аргаар гүйцэтгэхэд дээрх хугацааг мөрдөнө. Хэрэв 2 группийн аргаар ажиллагаа хийгдвэл ТБҮ, АТБҮ-ийн хугацаа 50% буурна. Вагоны тооноос хамаарч нэг вагонд 1.3 минутаар тооцож техникийн бүрэн үзлэгийн хугацааг тогтооно.

Тухайлбал 28 вагонтой бол $28 * 1,3 = 36,4 \approx 37$ минутаар тооцно.

Хүснэгт № 4. Дамжуулах өртөөнөөс явуулах тэгш, сондгой чиглэлийн галт тэргэнд хийгдэх үлгэрчилсэн технологит ажилбар

№	Гүйцэтгэх ажиллагаа	Хугацаа /хүртэл мин/	Хугацаа /мин/										Гүйцэтгэх ажилтан
			10	20	30	40	50	60	70	80	90	100	
1	Явах галт тэрэгний бүрэлдэхүүн бэлэн болж зүтгүүр оруулж байгаа талаар холбогдох ажилтнуудад урьдчилан мэдэгдэх.	Галт тэрэг явахаас өмнө											Өртөөний жижүүр
2	Галт тэрэг явуулах ажилтнууд хүлээн авах, явуулах зам руу явах.												Өртөөний жижүүр, туслах жижүүр Хүлээн авах талын вагон үзэгч-засварчин, ачаа вагон хүлээлцэгч
3	Бүрэлдэхүүнийг хамгаалалтад авч, дэвтэрт тэмдэглэл хийх.	1 мин											Хүлээлгэн өгөх талын вагон үзэгч-засварчин, ачаа вагон хүлээлцэгч
4	Галт тэргийг бодит байдлаас бичих, биечилсэн хуудас үйлдэх.	20 мин 25 мин 25 мин 30 мин											Туслах жижүүр
5	Тоормосны бүрэн туршилт хийх.	25 мин 35 мин 35 мин 45 мин											Хүлээн авсан талын вагон үзэгч-засварчин
6	Тоормос турших явцад илэрсэн гэмтлийг арилгах.	Тоормосын хийн ажиллагаатай эд ангиудын гэмтлийг арилгана. Засварын хугацааг үзлэгийн хугацаанд нэмж тооцно.											Хүлээлгэн өгсөн талын вагон үзэгч-засварчин
7	Галт тэрэгний машинчид биечилсэн хуудас гардуулан өгч, тулгах.	5 мин											Туслах жижүүр
8	Хөдлөх бүрэлдэхүүнээс тоормосны ивүүр авах.	5 мин											Өртөөний жижүүр, туслах жижүүр, найруулагчийн бригад, машинч
9	Хамгаалалт буулгаж, дэвтэрт тэмдэглэл хийх.	1 мин											Хүлээлгэн өгөх талын өртөөний жижүүр, ахлах үзэгч, ачаа вагон хүлээлцэгч
10	Замнал бэлтгэх, гаргах гэрлэн дохио нээх /хоорондын зам эзлэх маягт олгох/, галт тэргийг үдэн гаргах.	5 мин											Өртөөний жижүүр, туслах жижүүр, хүлээн авах талын вагон үзэгч-засварчин, ачаа вагон хүлээлцэгч
Нийт хугацаа		37 мин 47 мин 47 мин 57 мин											


10 хүртэл вагон
 31-50 хүртэл вагон
 11-30 хүртэл вагон
 51-80 хүртэл вагон

Жич: Галт тэрэгний техникийн бүрэн үзлэгийг 1 группийн аргаар гүйцэтгэхэд дээрх хугацааг мөрдөнө. Хэрэв 2 группийн аргаар ажиллагаа хийгдвэл ТБҮ, АТБҮ-ийн хугацаа 50% буурна. Вагоны тооноос хамаарч нэг вагонд 1.3 минутаар тооцож техникийн бүрэн үзлэгийн хугацааг тогтооно.

Тухайлбал 28 вагонтой бол $28 * 1,3 = 36,4 \approx 37$ минутаар тооцно.

Хүснэгт № 5. Дамжуулах өртөөнд ирсэн галт тэргэнд ачаа тээврийн үзлэг хийх технологит ажилбар (1 АВХ)

д/д	Гүйцэтгэх ажиллагаа	Хугацаа (хүртэл минут)	Хугацаа (мин)										
			10	20	30	40	50	60	70	80	90	100	110
1	Цахим ГҮ-98Б дэвтэр маягтанд тухайн замыг хамгаалалтанд авч, ачаа тээврийн үзлэг эхлүүлэх зөвшөөрөл өгөх	30 сек											
2	Цахим ГҮ-98Б дэвтэр маягтад АВХ ачаа тээврийн үзлэг эхлүүлсэн тухай тэмдэглэл хийх	30 сек											
3	Галт тэргэнд ачаа тээврийн үзлэгийг АВХ хийх	30 хүртэл вн 40 минут											
		60 хүртэл вн 70 минут											
		80 хүртэл вн 90 минут											
		100 хүртэл вн 110 минут											
4	Ачаа тээврийн дутагдал илэрсэн тохиолдолд ЕМА тогтоох, тээврийн бичиг баримттай тулган шалгах	5 минут											
5	Илэрсэн ачаа тээврийн дутагдлыг арилгах	хугацаа тогтоохгүй											
6	Тээврийн бичиг баримтанд ЕМА-ны дугаар тэмдэглэх	30 сек											
7	Цахим ГҮ-98Б дэвтэр маягтад АВХ тэмдэглэл хийж үзлэгийг хаах.	30 сек											
8	Бүрэн үзлэг хийх хугацааны нийлбэр	30 хүртэл вн 47 минут											
		60 хүртэл вн 77 минут											
		80 хүртэл вн 97 минут											
		100 хүртэл вн 117 минут											



Хүснэгт № 6. Галт тэргэнд ачаа тээврийн үзлэг хийх хугацааны норм

д/д	Галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагон тоо	1 АВХ	2 АВХ	3 АВХ	4 АВХ
1	30 хүртэл вагон	40	30		
2	31-60 хүртэл вагон	70	52	45	20
3	61-80 хүртэл вагон	90	67	54	45
4	81-100 хүртэл вагон	110	82	66	55

5.1.5. Суурь бүтэц эзэмшигч нар нь галт тэргэнд хийгдэх технологит ажилбарууд (хүснэгт№ 4,5,6)-ыг “Суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох, ачаа, хөдлөх бүрэлдэхүүн солилцох гэрээ”-д тусгасан байна.

5.1.6. Хилийн Сүхбаатар-Наушки, Замын-Үүд-Эрээн хилийн өртөөдөд БНХАУ, ОХУ-тай байгуулсан хилийн төмөр замуудын зөвлөгөөний протоколын хавсралтад заасан технологит ажилбарын дагуу хийнэ.

5.1.7. Ачааг тээвэрлэлтэд хүлээн авсан өртөө нь хүрэх өртөө хүртэл ачааны бүрэн бүтэн байдлыг хариуцна.

5.1.8. Уулзварын өртөөнд ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх

5.1.8.1 Уулзварын өртөөнд галт тэрэг солилцооны технологийн горимыг (шаардлагатай тохиолдолд журмаар зохицуулна) суурь бүтэц эзэмшигч нар хамтран боловсруулж, мөрдөнө.

5.1.8.2 Уулзварын өртөөнд ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх ажиллагааг суурь бүтцүүдийн ажилчид хамтран гүйцэтгэнэ.

5.1.8.3 Ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх ажиллагааг “Суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх гэрээ”-ээр зохицуулна.

5.1.8.4 Вагоны эд ангийг зайлшгүй солих шаардлага гарвал хүлээлгэн өгч буй талд буюу вагон эзэмшигчид албан ёсоор мэдэгдэнэ.


5.1.8.5 Салгалттай засвараар засварлах боломжгүй гэмтэл, засварын үечлэлийн норм дууссан вагонуудыг “Галт тэргэнд холбож явуулах мэдэгдэл” (маягт ВУ-26)-ийг үйлдэж засварын газар бүхий өртөө рүү илгээнэ.

5.2. Дамжуулах өртөөнд галт тэрэг солилцох хугацаа.

